

Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой

1. Өндөр дээд түвшний харилцан айлчлал

- УИХ-ын дарга М.Энхболдын Япон улсад хийсэн айлчлал (3 сарын 27-31-ний өдөр)

Айлчлалын бүрэлдэхүүнд Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Монгол, Японы Парламентын бүлгийн гишүүд зэрэг багтав.

- Монголын талаас Япон улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Оошима, Зөвлөхүүдийн танхимын дарга Ч.Датэ, Япон, Монголын Парламентын найрамдлын бүлгийн гишүүд болон Гадаад харилцааны сайд Ф.Кишидад Монгол улсад айлчлах урилга илгээсэн

45 жилийн тэмдэглэлт ойн жилийн хүрээнд Японы талаас ч өндөр дээд хэмжээний айлчлал хийх талаар судалж буй

2. Гадаад харилцаа, аюулгүй байдал

- Япон, Монголын Гадаад харилцааны яамд хоорондын Стратегийн зөвлөлдөх II-р уулзалт (2 сарын 21-ний өдөр)
- “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих хээрийн хамтарсан сургуульд Япон улсын оролцоо (7 сараас 8 сар) зэрэг, Батлан хамгаалахын харилцаа хамтын ажиллагааг эрчимжүүлэх.

3. Эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагаа

- Япон, Монгол улсын Эдийн засгийн Түншлэлийн хэлэлцээр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хоёр орны гадаад худалдааг өргөтгөх семинар (2 сарын 21-нд)
- Япон, Монгол улсын техникийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ (ХАА-н салбарт) (5 сарын 30-31)
- Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв байгуулагдсаны 15 жилийн ойн ёслолын арга хэмжээ (6 сарын 21-нд)
- Япон-Монголын Засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан VIII зөвлөлдөх уулзалт (7 сард зохион байгуулахаар төлөвлөж буй)
- Япон-Монголын сургалтын эмнэлэгийн барилгын шав тавих ёслол (9 сараас хойш зохион байгуулахаар төлөвлөж буй)
- ЖАЙКА-аас Монгол улсад далайн чанад дахь сайн дурын гишүүн илгээсний 25 жилийн ойн ёслолын арга хэмжээ (9 сард)

4. Соёлын арга хэмжээ

- UB Kimono Fashion show (3 сарын 24, 25-нд)
Японы үндэсний хувцас кимоно болон Монгол загвар зохион бүтээгчийн загварыг үзүүлэв.
- Япон, Монголын соёлын харилцааны арга хэмжээ Үндэсний их наадам (5 сард)
Японы уламжлалт үндэсний бүжгийн нэрт төлөөлөгчийн хөгжим, бүжгийн тоглолт
- Комаки балетын театрын тоглолт (6 сард)
- Поп соёлын өдөрлөг (Зуны улиралд)
- Японы орон нутгийн урлагийн зөвлөлөөс зохион байгуулах Японы уламжлалт соёлын тоглолт (8 сарын 19-нд)



45 жилийн ойн лого



Кимоно загварын шоу

5. Боловсрол, ард иргэдийн харилцаа

- Энэ жил Япон улсын Засгийн газар Монгол улсаас Япон улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр 50 оюутан, Инженер Технологийн дээд боловсролыг дэмжих төслөөр 26 оюутан, Хүний Нөөцийн Хөгжлийг Дэмжих JDS тэтгэлэгт хөтөлбөрөөр 20 оюутан, JENESYS хөтөлбөрөөр 87 хүүхэд залуусыг хүлээн авахаар төлөвлөж байна. (Өнөөгийн байдлаар Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрөөр 1400 оюутан, Инженер Технологийн дээд боловсролыг дэмжих төслөөр 30 оюутан, Хүний Нөөцийн Хөгжлийг Дэмжих JDS Тэтгэлэгт Хөтөлбөрөөр 280 оюутан, JENESYS хөтөлбөрт ойролцоогоор 720 залуус хамрагдаад байна)
- МУИС-ийн хууль зүйн сургуулийн дэргэдэх Нагоягийн их сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн 10 жилийн ойн ёслолын арга хэмжээ (3 сарын 20)
- Япон хэлний сургалтыг дэмжих (одоогоор Монгол улсад Япон хэл сонирхон судалж буй 10,000 гаруй хүн бий)